



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/377

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2229, Их Монгол улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн баярыг тохиолдуулан Ард иргэдийнхээ амгалан, тайван амьдрах орчин бүрдүүлэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйлсэд үнэтэй хувь оруулан хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 120000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 120000 төгрөг/нэг зуун хорин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 08-ны өдрийн
А/377 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

| № | Овог нэр | Эрхэлж буй ажил, албан тушаал | Мөнгөн дүн |
|-----|----------------|---|------------|
| 1 | М.Гантулга | Цагдаагийн газрын бичиг хэргийн эрхлэгч, дэд ахлагч | 30000 |
| 2 | Г.Баатарсүрэн | Замын цагдаагийн тасгийн зохицуулагч, ахлах ахлагч | 30000 |
| 3 | Т.Бат-Очир | Булган сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эдийн засгийн мөрдөгч, ахлах дэслэгч | 30000 |
| 4 | Б.Саруултайван | Дотоодын цэргийн тусгай салбарын харуулчин, дэд ахлагч | 30000 |
| Дүн | | | 120000 |

-оОо-